



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/763

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2021 оны Үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг олон нийтэд сурталчлах зорилгоор “Ховд-2021” сэтгүүлийн хэвлэлтийн зардалд 24 750 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 24 750 000 төгрөг /Хорин дөрвөн сая долоон зуун тавин мянган/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 4.6-д тусгагдсан “Оюунтүлхүүр” хөтөлбөрийн зардлаас 20 000 000 төгрөг/хорин сая/-ийг, 4.15-д тусгагдсан “Хариуцлагатай, тунгалаг төр” хөтөлбөрийн зардлаас 4 750 000 төгрөг /дөрвөн сая долоон зуун тавин мянган/-ийг санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 13-ны өдрийн  
А/763 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Төрөл	Төсөв /Төг/	Нийт төсөв /Төг/
1	Сэтгүүл хэвлэх зардал	8000 ширхэг	8000*3000	24 000 000
2	Тээврийн зардал		3000 ш	750 000
Нийт дүн				24 750 000

-oOo-